

Монгол Алтайн хадны зураг дахь зарим нарийн зураасан зураг

Мүшелханы Адилбек^{1,*}

Товч агуулга: Тус өгүүлэлд Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Цагаан Салаа-Бага Ойгор, Буянт сумын Хойд Хөлцөөт, Цэнгэл сумын Шивээт хайрханы хадны зураг дахь нарийн зураасан зургийн дүр дүрслэл, арга барил, сэдэв зохиомж, он цагийн хамаарал зэргийг харьцуулан авч үзэв. Эдгээр гурван дурсгалт газарт хадны зурагт элбэг тохиолддог буга, хүн, тэрэгний дүрслэл бүхий нийт 24 нарийн зураасан зураг байна. Эдгээр нь он цагийн хувьд хүрэл зэвсгийн үеэс Түрэгийн үед хамаарах ажээ.

Түлхүүр үг: Нарийн зураасан зураг, Хожуу хүрлийн үе, Түрүү төмрийн үе, Түрэгийн үе

Удиртгал

Монгол орны хувьд хамгийн ихээр сийлсэн хадны зургийн нэгэн төрөл бол сийлмэл аргаар урласан зургууд юм. Харин зосон, хар бэхэн зураг тун ховор байдаг бол нарийн зураасан зургийн хувьд арай илүү түгээмэл гэж хэлж болохоор байна. Монголын хадны зургийн энэ дөрвөн арга барилаас Монгол Алтай баруун хэсэг Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт гурав нь илэрч олдсон байна. Тухайлбал, сийлмэл зураг хамгийн их, нарийн зураасан зураг нэлээдгүй илэрч байгаа бол зосон зургийн дурсгал одоогоор ганц дурсгал илэрч олджээ. Харин он цагийн хамаарлын хувьд сийлмэл ба зосон зураг хамгийн эртний төрөлд багтдаг, харин нарийн зураасан зураг хүрлийн үеэс улбаатай гэж судлаачид үздэг юм (Цэвээндорж 1999: 142-146; Өмирбек 2019: 86-92).

Монгол Алтайн хадны зургийг судлах ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд судалгааны үр дүнд хурц үзүүртэй, нарийн багажаар сийлсэн зургийг хадны зурагт нарийн зураасан зураг гэж бие даасан сэдэв болгон судлаад байна. Монгол Алтайн баруун хэсэг Билүүт, Шивээт хайрхан, Хойд Хөлцөөт, Цагаан Салаа-Бага Ойгор, Хар магнай, Их Ойгор зэрэг томоохон хадны зургийн цогцолбор газруудад нарийн зураасан зургийн дурсгалууд ихээр илэрчээ.

Хадны зурагт нарийн хурц үзүүртэй багажаар сийлж урласан дүрслэлүүд элбэг тохиолддог бөгөөд үүнийг нарийн зураасан зураг хэмээн нэрлэдэг. Монгол орноос олдож буй нарийн зураасан зургийн хамгийн эртнийх нь чулуун зэвсгийн үе Хар чулуутын хадны зураг (Эрдэнэбат 2023: 11-26), мөн неолитын үе Хөрөөгийн үзүүрийн хадны зураг (Гантулга нар 2018: 51) хоёр юм.

Уг арга барилын үүссэн цаг хугацааг судлаачид

янз янзаар баримталдаг. Ийм нарийн зураасан зургийн дурсгалуудын он цагийг тогтоох нь тун төвөгтэй учраас ихэвчлэн сийлсэн арга барил, хэв маягт нь анхаарч, түүнийг археологийн олдвортой харьцуулан харьцангуй он цагийг тогтоосоор байна. Нарийн зураасан зургийг бас дотор нь хэд хэдэн төрөл болгон ангилж болно. Үүнд, гадна тэгийг хөвөөлсөн, торлосон, сараачмал гэх мэтээр ангилна (Өмирбек 2013: 33).

Эх хэрэглэгдэхүүн

Монгол Алтайн хадны зурагт буй олон үед холбогдох нарийн зураасан зургийн дурсгал, дүрслэлийг энэ өгүүллийн эх хэрэглэгдэхүүн болгон авч үзэв.

Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зургийн дурсгалт газар нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт, Шивээт хайрхан уул нь Цэнгэл сумын нутагт, харин Хойд Хөлцөөтийн хадны зургийн дурсгалт газар нь Буянт сумын нутагт тус тус оршдог.

Цагаан Салаа-Бага Ойгорын хойт талын уулнаа олон тооны ан амьтан, мал, хүн, ан гөрөө, аж ахуй, дайн байлдаан хийж буй зэрэг олон тооны зургуудыг хонхойлон цоолборлох, гадна тэгийг хөвөөлөн цохих хадны зураг дахь үндсэн хоёр аргыг хэрэглэж урласны хамт хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан зураг байна. Уг дурсгалт газрын хадны зураг нийт 11 секторт хуваагддаг бөгөөд үүнээс нарийн зураасан зураг нь Цагаан Салаа-I, Цагаан Салаа-II, Цагаан Салаа-IV мөн Бага Ойгор-III, Бага Ойгор-V секторуудад бий.

Шивээт хайрханы хадны зургуудын ихэнх нь уулынхаа бэлээр, Хар салаа голын зүүн эргээр тарсан хадны нурангийн хошуурсан хэсгүүдээр байрлана. Зураг бүхий хадны нийт талбай нь ойролцоогоор 10-12 хавтгай дөрвөлжин км ажээ.

Харин Хойд Хөлцөөт нь хадны зургийн тоо хэмжээний хувьд 2800 орчим зураг сийлжээ.

¹ МУИС, Антропологи, Археологийн тэнхим, магистрант

* Холбоо барих зохиогч: adkaadilbek@gmail.com

Хэлэлцүүлэг

Хадны сийлмэл зургийг дотор нь: а) хадыг хонхойлгон цоолборлож сийлсэн сийлмэл зураг, б) хурц үзүүртэй багажаар сийлж зурсан нарийн зураасан зураг гэсэн дэд хэсэгт хуваан үзэж болно. Хадыг хонхойлгон цохиж сийлсэн зургийг мөн дотор нь: а) бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлсэн, б) ямарваа нэгэн амьтны их биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохиж сийлсэн хэмээн ангилдаг байна. Түүнчлэн судлаачид хадны сийлмэл зургийг дүрсэлсэн хэв маягаар нь: а) бодит байдлаар дүрсэлсэн, б) загварчлан [амьтныг загварчлан дүрслэх аргаар] дүрсэлсэн хэмээн хоёр төрөлд хуваан үздэг (Цэвээндорж 1999: 68).

Хадыг хонхойлгон цохиж сийлсэн зургийг тархац болон тооны хувьд хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан болон зос, бэхээр зурсан зургаас их байдаг нь бусад төрлийн зургаасаа бат бэх, илүү сайн хадгалагдах чанартай холбоотой, түүнийг хаднаа цохиж сийлэх нь илүү боломжтой байсан (Цэвээндорж 1999: 68) бололтой.

Харин эртний хүмүүс төмөрлөгийг ашиглаж эхэлснээр зэвсэг багаж нь сайжирч дээрхи аргаас үүсэлтэйгээр нарийн үзүүртэй багажаар амьтан, хүний биеийг хөвөөлөн сийлэх болсон нь хүрлийн сүүл, төмрийн түрүү үеэс эхлэн Түрэгийн үед нэлээд дэлгэрчээ.

Монгол Алтайн баруун хэсэг болон дээрх дурсгалт газруудаас илэрсэн нарийн зураасан зургийг ажиглахад тоймлосон, өгүүлэмж, агуулга, зохиомж, мөн болхи дутуу зурагдсан хэлбэрээр илэрч байна. Зарим тохиолдолд эртний руни бичгийн дурсгалтай хамт, заримдаа эртний тамга тэмдгийн хамт тохиолдож байгаа нь нарийн багаж өөрөөр хэлбэл хадны зураг сийлэх багаж хэрэгслийн хөгжлийг харуулахаас гадна нийгмийн хөгжил дэвшлийг давхар харуулж байдаг.

Бид энэ удаад хадны зурагт нарийн зураасаар саарчин, сийлж урласан бугын дүрс, хүний дүрс, тэрэгний дүрслэлийн талаар авч үзэв.

Буга. Хадны зурагт бугын дүрсийг ихэвчлэн бодит, чимэглэсэн, загварчилсан хэв маягаар дүрсэлж урласан байдаг. Бугын дүрсийг заримдаа болхи болон бодит байдлаар их биеийг нь бүх талбайгаар нь цохиж цоолборлох, гадна тэгийг хөвөөлөн цохиж цоолборлох, нарийн зураасаар зурах, сараачин, чимэглэх аргаар урласан нь тохиолдоно. Монгол Алтайн хадны зурагт нарийн зураасан зургаар загварчилсан бугыг сийлээд сараачин нарийн зураасаар торлосон тохиолдол илэрч байгаа билээ. Ийм дүрслэлүүд Монгол орны Баянхонгор аймгийн Зурагтын хад, Увс аймгийн Давс сумын зэрэг хэд хэдэн газрын хадны зурагт (Цэвээндорж 1999: 127) тааралддаг байна.

Цагаан Салаа II дурсгалт газрын хадны зурагт

нэгэн бугыг урт нарийхан хоншоортой эх биеэ дагасан олон салаа хээ угалз мэт урт эвэртэй, нарийхан чихтэй, дугираг нүдтэй, урт хүзүүтэй өндөр сэрвээтэй, ихэд шавхнуун гэдэстэй нарийхан хөлтэй амьтныг загварчилсан дүрслэх аргаар дүрсэлж гаднах тэгийг хөвөөлөн дүрсэлсэн доторх зайг хөндлөн тууш олон нарийн зураасаар зуржээ (Зураг 1).

Цагаан Салаа II дурсгалт газарт нэг том буга түүний араас дагаж яваа согоо, хоёр чоно урдаас нь тосч зогссон үхэр зэрэг амьтдыг дүрсэлсний хамгийн гол дунд буй бугын зураг онц сонирхолтой. Тэр бугын эх биеийг үхрийнх шиг урт зууван дөрвөлжин хэлбэртэй хөвөөлөн цохиж дүрслээд хөндлөн ба, тууш өргөн зураасаар тор мэт дөрвөлжин чимжээ. Дөрвөн хөлийг нарийхан шулуун, сүүлийг нь богино, үзүүртээ дугираг хэлбэртэй дүрсэлж зөвхөн цээжний урьд талыг бүх талбайгаар нь хонхойлжээ (Зураг 2). Бугын толгой, хоншоор, үхэрийнх шиг хоёр том данхар бөгөөд гадна тийшээ 28 салаа эврийг нь нарийн зураасаар зуржээ. Энэ зурагт хаднаа амьтны дүрсийг бүх талбайгаар нь хонхойлж цохих, эх биеийг “торлож” чимэх, хурц үзүүртэй багажаар нарийн зураас гарган зурах аргуудыг нэг доор хамт хэрэглэсэн байна (Цэвээндорж 1999: 77).

Цагаан Салаа IV дурсгалт газарт олон салаа эвэртэй нэг том бугын нуруун дээр давхарлуулан, амаа ангайсан хоёр том соотон чихтэй урт нарийн сүүлтэй чоно нохой мэт амьтныг зогсч буйгаар нарийн зураасаар дүрсэлжээ (Гэрэл зураг 1).

Харин Бага Ойгор V дурсгалт газрын хадны дээд хэсэгт зүүн зүг рүү харсан олон салаат эвэртэй гурван бугыг нарийн зураасаар дүрсэлжээ. Дунд хэсэгт эсрэг буюу баруун тийш харсан бугын олон салаа урт эврийг нарийн зураасаар, их биеийн доторхи зайг сараачин дүрсэлжээ. Доод хэсэгт эртний үхэр болон янгирыг хойхойлон цохисон байна. Энэ хаднаа амьтны дүрсийг бүх талбайгаар нь хонхойлж цохих, хурц үзүүртэй багажаар нарийн зураас гарган зурах аргуудыг нэг доор хамт хэрэглэжээ (Гэрэл зураг 2).

Мөн Баян-Өлгий аймгийн Буянт сумын Хойд Хөлцөөтийн хадны зурагт 123 см урттай загварчилсан бугын нарийн зураасаар дүрсэлсэн байна (Зураг 3). Энд бугыг бодит, чимэглэх болон загварчилж олон арга барил, хэв маягаар сийлсэн байдаг. Хойд Хөлцөөтийн хадны зурагт 11 бугын их биеийг гадаад тэгийг хөвөөлөн цохиж, заримыг нь ар нуруу эх бие дээгүүр дээрээс доош босоо, ташуу зураас эгнүүлж чимэх зэргээр цохиж дүрсэлжээ (Өмирбек 2013: 45).

Бугын дүрсийг яг буган хөшөөн дээрхтэй адил урласан дүрслэл Монгол Алтайн хадны зурагт түгээмэл тааралдаж байна. Судлаачид буган хөшөөнд анх ийм загварчилсан дүрсийг урласан уу, хадны зурагт уу, аль нь анхдагч вэ гэсэн асуултанд санал зөрүүтэй байдаг. Хадны зурагт ийм загварчилсан

бугыг хоёр өөр аргаар дүрсэлсэн байжээ. Нэгдүгээрт, нарийн зураасаар сийлсэн загварчилсан буга, хоёрдугаарт, бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлээд дараа нь засаж, зүлгэж тэгшилсэн дүрслэл юм (Өмирбек 2013:45).

Хүнийн дүрс. Хадны зурагт хүний дүрсийг янз янзаар зурсан хүний дүр ихээр тааралддаг. Неолитын үед анхдагч шүтлэгийн хэлбэрүүд төгөлдөржин хөгжиж, бөө мөргөлийн анхны хэлбэрүүд бий болсноор хадны зургийн урлагт хүний дүрслэл, түүний дотор бөө нар болон шүтлэг бишрэл, зан үйлтэй холбоотой хүний нүүрний багийн дүрс хадны зурагт олноор дүрслэгдэх болжээ. Монгол орноос олдсон хүний нүүрний баг болон хөрш зэргэлдээх орнуудын хадны зургаас олдсон нүүрний баг, зарим бөө нарын дүрслэлийг неолитын үед холбон тайлбарладаг байна (Өмирбек 2023: 100).

Мөн хүрлийн үеийн хадны зурагт хүнийг хувцас хунар, зэр зэвсэг агсаж, амьтан хөтөлсөн, мал гаршуулж буй морь, үхэр, тэмээ унасан зэргээр мөн нүүдэл суудал, нуруу ачаатай үхэр, үхэр тэрэг, морин тэрэг, тэрэгний дүрслэл, мод уул, ус тамга тэмдэг зэрэг үйл хөдлөл эд зүйлс, ан ав хийж буй зэргийг дангаар нь болон зохиомжид оруулж сийлэх нь түгээмэл тааралддаг. Хадны зураг хүний дүрсийг сийлмэл аргаар цохиж урласан мөн хурц үзүүртэй багажаар зурсан нарийн зураасан зургууд ч тохиолдож байна.

Цагаан Салаа II дурсгалт газарт дээш сортойсон хос чихтэй малгай өмсч нэгэн гартаа урт иштэй босоодуу тарпец хэлбэрийн эдлэл (зэвсэг буюу туг сүлд байж болох) дээш нь гозойлгон өргөж бүсэндээ бамбай мэт том дугуй зүйл зүүсэн хүнийг нарийн зураасаар дүрсэлжээ (Зураг 4). Түүний урд олон босоо хөндлөн зураасаар зурсан дөрвөлжин дүрс, зурааснууд байна (Цэвээндорж 1999: 77).

Цагаан Салаа II талбайд (Зураг 5) хүний эх бие хүзүү, хоёр хөл зэргийг хоёр зэрэглээ зураасаар, гар бэлгэ эрхтэн зэргийг ганц зураасаар тоймлон зуржээ. Харин нүд хөмсөг, хамар, ам, чихийг тодорхой гаргасан байна. Хэдийгээр анчинг нэлээд загварчилан дүрсэлсэн боловч түүний нүүрний дүрс эртний Түрэгийн хүн чулууны нүүрний дүрслэлийн ерөнхий тигтэй төстэй байна хэмээн уг дурсгалыг судалсан эрдэмтэд үзжээ.

Түрэгийн үед холбогдуулах үндэслэл нь зурсан арга барил техникийн шинжүүд, хүмүүсийн гээг үс, морины дэлний засалт зэрэг нарийн угсаатны шинжийг харуулах дүрслэлийн шинжүүд (Төрбат нар 2009: 160) байна. Хүн баруун гараараа эгэлдрэг, тохош, хударга бүхий морины цулбуураас хөтөлжээ. Хүн бугын нуруу дээд талаас дал руу нь том зүймэл нумаар харваж буйг тоймлон дүрсэлжээ Олон салаа шулуун эвэртэй бугын дүрийг тоймлосон байдалтай зураад дээгүүр нь олон шулуун зураасаар эгнүүлэн

сараачжээ. Бугыг нарийн хоншоортой урт нарийн чихтэй дүрсэлжээ. Бугын хэвлий доор, мөн цээжин доор нь урт чихтэй, урт сүүлтэй хоёр чоно нохой мэт амьтны хорьж хороосон байдалтай зуржээ. Түүнтэй ижил нэгэн зохиомжинд оруулан нарийн зураасаар сийлж дүрсэлсэн зураасан зургийн дурсгал Хар магнайн хадны зурагт тааралдаж байна (Өмирбек 2014:6). Хар магнай хэмээх дурсгалт газарт сийлсэн нум сумтай анчны бүснээс зүүсэн адууг нь мөн адилхан дөрөөгүй, эмээлтэй, хөмөлдөрөг, хударгатай сийлжээ. Түүнийг нохой дагуулан, ан агнаж байгаагаар дүрсэлжээ (Зураг 6).

Шивээт хайрханы хадны зурагт сийлмэл ба бүх тайлбайгаар нь цохих аргыг хослуулсан нэгэн зураг нэлээд өвөрмөц юм. Энэ зурагт гурван морьтонг дүрслэхдээ хүрээг нь нарийн сараачмал зурсаар гаргаад дараа нь бүх талбайгаар нь цохиж байсан нь тодорхой мэдэгдэж байна. Хамгийн дээд талын морьтонг бүх талбайгаар нь цохиж дуусгасан бол дундах морьтны дүрсийг сараачиж гаргаад хүнийг нь бүх талбайгаар цохиж, харин морийг нь зарим тоног хэрэгсэлийг (эмээл, хазаар, хударга, хөмөлдөрөг) дүрслэх үүднээс зөвхөн хүрээлэн цохисон байх бол хамгийн доодох морьтонг цохиж байгаад дутуу орхисон бололтой байна. Морьдыг эмээл, хазаар, хударга, хөмөлдөрөг бүрэн хэрэглэлтэй дүрсэлсэн байна. Мөн морьдын хүзүүнээс бөмбөлгөн хонх зүүж, духавч зүүсэн байжээ. Морины зоог дагасан 3-5 тоногтой хөмөлдөрөгийг маш тодорхой дүрсэлхийн тулд бүгдийг нь морины явдал дунд үсчин дээш хөөрсөн мэтээр босоо байдалтай дүрсэлжээ.

Шивээт хайрхан уулын Хар салаа хэмээх газарт маш олон сэдэв зохиомжтой хадны зураг тааралддаг билээ. Хар салаа IV дурсгалт газарт эмээлтэй морь унасан гурван хүнийг нарийн зураасаар дүрсэлжээ. Тэдний нэг нь гээгтэй хүн, хоёр дахь хүн нь гурван эвэр бүхий толгойн өмсгөлтэй хүн байна (Гэрэл зураг 3). Энэхүү зургийг судлаачид Түрэгийн үед хамруулан үзжээ (Цэвээндорж нар 2010: 32).

Иймэрхүү хадны зурагт дөрөөгүй, эмээлтэй морь унасан хүний нарийн зураасан зургууд Монгол Алтайн хадны зурагт ихээр олдож байгаа бөгөөд ихэнхи нь дээрхи зохиомжтой ижил төстэй байгаа нь нэгэн үед бүтээгдсэн байж болох таамгийг төрүүлээд байна. Түүнчлэн эдгээр зохиомж дахь хүнийг ямагт эгц өөдөөс /урдаас/ харсан байдлаар сийлж урласаныг бодвол нэгэн зураач юм уу, тогтсон нэгэн загвараар, ойролцоо цаг хугацаанд дүрсэлсэн байж болохыг харуулна (Өмирбек 2014: 2). Монгол Алтайн Цагаан Салаа, Бага Ойгор, Билүүт, Хойд Хөлцөөтийн хадны зургуудад тун төстэй зохиомжтой нарийн зураасан зургууд илэрч олджээ.

Тэрэг. Монголын хадны урлагт, тэр дундаа Монгол Алтайн хадны зураг төрөл бүрийн тэрэгний

дүрслэл ихэд түгээмэл тархсан байдаг (Цэвээндорж 2010: 65). Тэргийг хад цохионд сийлж урлах арга барил, хэв маяг, сэдэв зохиомжинд оруулсан зэрэг онц сонирхолтой судалгааг судлаачид олон жилийн өмнөөс хийж иржээ. Монгол Алтайн Шивээт хайрхан, Цагаан Салаа-Бага Ойгор, Хойд Хөлцөөт, Билүүт, Зүүн хөх хөтөл, Арал толгой гэх зэрэг нэлээд газраас нийтдээ 154 ширхэг тэрэгний дүрслэл олддоод байна (Өмирбек 2019: 160). Тэрэгний дүрслэлийг хүрлийн үеэс эхэлж сийлсэн гэж судлаачид үздэг. Хадны зураг дахь тэрэгний хэлбэр, дүрс, зориулалт нь олон янзын бөгөөд хос дугуйтай, дөрвөн дугуйтай, нарийн зураасаар зурсан олон хигээст дугуйтай, цулгуй дугуйт, цагариглан дүрсэлсэн дугуйт, зууван дугуйт, хайнга дүрсэлсэн хэлбэр нь өөр өөр дугуйт, голтой, гуя, аралтай, хос аралтай, чихтэй, тэвштэй, тавцантай, хос цулбууртай, 4-5 буюу олон цулбууртай, буулгатай, мөн эзэнгүй, эзэнтэй, мөөгөн малгайт хүн зогссон, нум, сум, хорч агссан, байлдааны зээтүү бүснээс зүүсэн анчин бололтой тэрэгчинтэй, тэвшинд хүн хэвтүүлсэн, гар хоосон хос хүнийг дүрсэлсэн, морин тэрэг, шар хөллөсөн тэрэг, үхэр тэрэг, түрдэг тэрэг, гэр тэрэг, чингэлэгт тэрэг, сүйх тэрэг, шүхэрт тэрэг, мухлагт тэрэг, чиргүүлтэй мэт тэрэг гээд ангилж үзжээ.

Нарийн зураасан зургаар сийлсэн тэрэгний дүрслэл Монгол Алтайн баруун хэсэг болох Цагаан Салаа, Бага Ойгор, Шивээт хайрхан (Цэвээндорж нар 2010: 117), Хойд Хөлцөөтийн хадны зурагт дүрслэгдсэн (Өмирбек 2012: 91) байдаг (Зураг 7). Зурсан арга барил, хэв маягийн хувьд нилээд болхи, дугуй болон хигээсийг гаргаж сийлсэн боловч зарим тоног хэрэгслийг сийлээгүй дутуу, маш болхи дүрсэлсэн байна. Хадны зурагт нарийн зураасаар сийлсэн тэрэгний дүрслэлийг маш муу урласан байдаг нь түгээмэл харагддаг билээ. Энэ үзэгдэл нь нарийн зураасан зурагт тэрэгний дүрсийг сайн урлаж буулгахад хэцүү, эсхүл зураачийн ур чадвар дутмаг бөгөөд зурахдаа хайнгадуу хандсан байж болох юм.

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дахь Шивээт Хайрхан уулнаас Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон нар нийтдээ 66 тэрэгний дүрслэлийг олж судалсан байна (Цэвээндорж нар 2010: 72). Шивээт Хайрхан уулын зүүн бэлийн Хар салаа III хэмээх дурсгалт газрын 140 x 70 см хэмжээтэй чулуун хавтан дээр хос морь хөллөсөн 9 тэрэгний том жижиг дүрс байгаагаас хамгийн том нь уртаашаа 60 орчим см хэмжээтэй байв. Нэг дор ийм олон тэргийг дүрсэлсэн дурсгалт газрыг Д.Цэвээндорж, Б.Гүнчинсүрэн (Цэвээндорж нар 2010: 66-68) нар “морин тэрэгний зогсоол” хэмээн нэрлэсэн байжээ.

Шивээт хайрханы өөр нэг секторт нэг дор хүрлийн үеийн тэрэгний дүрслэлүүдийг нарийн зураасан зургаар сараачин дүрсэлжээ. Шивээт хайрханы

хадны зурагт ч нарийн зураасаар сараачин дүрсэлсэн тэрэгний дүрслэлийг болхи урласан байжээ. Цаг хугацааны хувьд хүннүгийн үеэс өмнөх, төмрийн түрүү үед холбогдож магадгүй хэмээн доктор Б.Өмирбек өгүүлэлдээ дурджээ. Учир нь Хүннүгийн үеийн ийм нарийн зураасаар сараачин сийлсэн эд өлгийн дурсгал дээрх тэрэгний дүрслэл нилээд бодит байдаг билээ.

Хойд Хөлцөөтийн Хар өлкен хэмээх дурсгалт газарт-хигээстэй хос цагариган дугуйг голын дугуй тэвштэй холбож тэвшнээс дээшээ хоёр нарийн зураасыг үзүүрээр нийлүүлж дүрсэлсэн тэрэгний дүрслэл байна. Голын тэвшийг нарийн зураасаар чагтлан торлож сийлжээ. Уг тэргийг хурц үзүүртэй багаж ашиглан нарийн зураасаар сийлж урласан байна (Зураг 8).

Дүгнэлт

Тус өгүүлэлд Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт орших Цагаан Салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Хойд Хөлцөөтийн хадны зургийн цогцолборын нарийн зураасан зургийн зарим дүр дүрслэлийг тусгайлан авч үзлээ. Нарийн зураасан зураг сийлж урласан хадны зурагт ан амьтан, эртний аж ахуйн сэдэвт, хүний дүрслэл, тэрэг, морьтон зэрэг дурсгалууд багтаж байна.

Нарийн зураасан зургийг дотор нь: 1) гадна тэгийг нарийн зураасаар хөвөөлөн зурж сийлэх, 2) гадна тэгийг нарийн зураасаар хөвөөлөн сийлж, доторх талбайг нь ташуу зураасаар сийлж сараачих, 3) эх биенийг нь нарийн зураасаар будаж сийлэх гэж ангилалд багтаан судалж үзэхээр байна.

Хадны зурагт хурц үзүүртэй багажаар нарийн зураас гарган зурах, хаднаа амьтны дүрсийг бүх талбайгаар нь хонхойлж цохих, эх биенийг “торлож” чимэх, аргуудыг хэрэглэсэн байна. Монгол Алтайд илэрч байгаа нарийн зураасан зураг он цагийн хувьд загварчилсан, чимэглэх аргаар бүтсэн зургууд хүрлийн сүүл, төмрийн түрүү үед хамаарах бол зарим зураг сэдэв зохиомжийг Түрэгийн үед хамруулан авч үзэв.

Хэдийгээр нарийн зураасан зураг нь бие даасан хадны зургийн нэг төрөл боловч заримдаа сийлмэл зурагтай хосолмол аргаар, эсвэл эскиз маягаар дэвсгэр зураг хэлбэрээр тохиолдохоос гадна сийлмэл зургийн өгүүлэмж, сэдэв зохиомжтой ижил төсөөтэй дүрслэгдсэнийг бодвол “хосолмол”, “холимог” аргуудын нэг болов уу гэсэн таамаг төрүүлнэ.

Abstract**Incised graffiti on the rock art of Mongolian Altai****Mushyelkhan Adilbyek**

This article discusses a comparative analysis of the detailed images, methods, thematic compositions, and chronological context of incised graffiti found in the rock art of Tsagaan Salaa-Baga Oigor of Ulaankhus soum, Shiveet Khaikhan of Tsengel soum, and Khoid Khölsööt in Buyant soum of the Bayan-Olgii Province, in the western region of the Mongolian Altai. At these three sites, a total of 24 incised images are present, showcasing depictions such as deer, which are frequently encountered in petroglyphs, alongside representations of humans and chariots. Chronologically, these carvings range from the Bronze Age to the Turkic period.

Keywords: Incised graffiti, Late Bronze Age, Early Iron Age, Turkic period, Mongolia, Altai region

Ном зүй

Батболд, Н., Молодин, В.И., Черемисин, Д.В., Ненахова, Ю.Н. (2019). Монголын баруун хойд бүс нутагт хийсэн хадны зургийн судалгаа. Археологийн судлал. Том XXXVIII, Fasc. 2. УБ., 2019.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. (2018). Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа. УБ., 2018

Өмирбек, Б., (2013). “Монгол Алтайн нурууны Хойд Хөлцөөтийн хадны зургийн судалгааны асуудалд”. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон бүтээлийн гар бичмэл. УБ., 2013

Өмирбек, Б., (2019). Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд. УБ., 2019.

Кубарев, В.Д., Цэвээндорж, Д., Якобсон, Э. (2005). Петроглифы Цагаан Салаа и Бага Ойгура (Монгольский Алтай). Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, 2005. – 442 с.

Төрбат, Ц., Батболд, Н., Өмирбек, Б., (2023). Монгол Алтайд илэрсэн палеолитийн үеийн хадны зургийн шинэ дурсгал: Бага Ойгор-6 (танилцуулга өгүүлэл) Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology 2023, Vol. 12 (1), No. 2, 27-35.

Төрбат, Ц., Баяр, Д., Цэвээндорж, Д., Баттулга, Ц., Баярхүү, Н., Идэрхангай, Т., Жискара, П.Х., (2009). Монгол Алтайн археологийн дурсгалууд-I: Баян-Өлгий аймаг. УБ., 2009.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн түүх. УБ., 1999.

Цэвээндорж, Д., Кубарев, В.Д., Якобсон, Э. (2010). Шивээт хайрханы хадны зураг. УБ., 2010.


Цэрэндагва, Я., Цэвээндорж, Д. (2016). Далан түргэний хос толгойн хадны зураг. УБ., 2016.

Эгиймаа, Ц. (2003). Хүннүгийн зураасан зургийн дурсгал. Археологийн судлал, Tomus I (XXI), Fasc.7. УБ., 2003: 69-74.


Эрдэнэбат, У. (2023). Хар чулуутын палеолитын хадны зураг. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology 2023, Vol. 12 (1), No. 1, 11-26.

Received: Apr 16, 2024; Revised: Apr 26, 2024; Accepted: May 13, 2024







Зураг 1. Цагаан Салаа-II (Кубарев нар 2005)



Зураг 2. Цагаан Салаа-II (Кубарев нар 2005)




Зураг 3. Хойд Хөлцөөтийн хадны зураг (Өмирбек 2013)




Зураг 4. Цагаан Салаа-II (Кубарев нар 2005)




Зураг 5. Цагаан Салаа-II (Кубарев нар 2005)



Зураг 6. Хар магнай (Өмирбек 2014: 6)



Зураг 7. Хар Салаа-III



Зураг 8. Хойд Хөлцөөтийн хадны зураг (Өмирбек 2013)



Зураг 9. Цагаан Салаа-IV



Зураг 10. Бага Ойгор-V



Зураг 11. Шивээт хайрхан (Гэрэл зургийг М.Адилбек)



Зураг 12. Хойд Хөлцөөт (Өмирбек 2019)